



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 11/25

Шивээговь сум

Сургуулийн дотуур байрны засварын  
ажлыг хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Сургуулийн дотуур байрны засвар”-ын ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч дарга)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

Ж.Наранцацрал

(Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны багш)

Хөндлөнгийн төлөөлөл:

Б.Дэлгэрдалай

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)


Ц.Одончимэг

(1 дүгээр багийн иргэн)

2. Сургуулийн дотуур байрны ажлыг байгууллагын хөрөнгөнд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Энхриймаа)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлага хангасан засварын ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан акт үйлдэж, холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ